



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ҮР ДҮНД ЧИГЛҮҮЛЭН ТӨЛӨВЛӨЖ, БАТЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Аудитын сэдэв: Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө, оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Аудитын код: ДГА-2025/06-08-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий
Утас: 70522734, Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер У.Оюунтүлхүүр
Утас: 70523020, Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор Э.Энхцэцэг
Цахим хаяг: enkhsetsege@audit.gov.mn

Аудитор Б.Ариунбаатар
Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

Аудитор М.Оюу-Эрдэнэ
Цахим хаяг: oyu-erdenem@audit.gov.mn



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/25

Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, 2021 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал", А/71 дүгээр тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын заавар, аргачлал", 2023 оны "Эрх, үүрэг шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсэг, 2024 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитаар тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэн, биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Замын-Үүд сумын ИТХ, Замын-Үүд сумын засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, 14 сумын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т үүрэг болгосугай.



Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2025 onii ajil/doc/Тушаал

442501005

АГУУЛГА:

Товьёг	2
Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4-5

БҮЛЭГ 1. ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ны жагсаалтад төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан ажлыг баталж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй ерөнхий утгаар нийцүүлэн төлөвлөсөн байна.....	6
1.2. ОНТХО-ыг иргэдийн санал, ЭЗ-ийн үр ашиг, нийгмийн ач холбогдолд үндэслэн тооцох төлөвлөлтийн шаардлага бүрэн хангагдаагүй байна.....	6-9
1.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хуульд заасан төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан ТАХ-г батлах шаардлагатай байна.....	9-12
1.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр орон нутгийн өмчлөлд шилжих боломжгүй 3,700.8 сая төгрөгийн 36 ТАХ-г төлөвлөж баталсан байна.....	12-14

БҮЛЭГ 2. Худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэх шаардлагатай байна.

2.1. ТЕЗ зарим ТАХ-ний тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг хуульд заасан хугацаанд шилжүүлээгүй байна	14-16
2.2. Сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн ТАХ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.....	16-19
2.3. Оролцогчийг ХАА-ны хууль, журам, тендерийн баримт бичигт заасан шалгуурын дагуу үнэлээгүйгээс зарим төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт цуцлагдсан байна.....	19-20

БҮЛЭГ 3. ОНХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилттэй холбоотой зөрчил давтагдан гарсан байна.

3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэхгүй олгосон зөрчил давтагдсан байна.....	20-23
3.2. ТАХ-г хэрэгжүүлэх гэрээний хугацааг ажлын тоо хэмжээ болон бусад хүчин зүйлстэй уялдуулан бүрэн хэрэгжих хугацаагаар төлөвлөж, батлах шаардлагатай байна.	23-26
3.3. Зураг, төсвийн дагуу хийгдээгүй, бүрэн хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.....	26-29
3.4. ОНХО-аар хэрэгжүүлж дууссан 10,912.5 сая төгрөгийн өртөгтэй 53 ТАХ-г ашиглагч байгууллагын НББ-д тусгаагүй байна.....	30-33

Дүгнэлт:34-35

Зөвлөмж:36

Тайлангийн төсөлд ирүүлсэн санал:37-43

Тайлангийн төсөлд ирүүлсэн саналд өгөх тайлбар:42

Тайлан баталгаажуулах тушаал:44

Тайлангийн хавсралт:45-48

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
АНТАГ	Аймаг, нийслэлийн төрийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ОНТАГ	Орон нутаг дахь Төрийн аудитын газар
ЭЗ	Эдийн засаг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УХО	Улсын хөрөнгө оруулалт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТХО	Төсвийн хөрөнгө оруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЭЗХЯ	Эдийн засаг хөгжлийн яам
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
СоС	Соёлын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ХАА	Худалдан авах ажиллагаа
УТ	Улсын төсөв
УКД	Улсын комиссын дугаар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
БХТ	Барилгын хөгжлийн төв
АТГ	Авлигатай тэмцэх газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
МУИХ	Монгол улсын Их хурал
УОНТХО	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Хүснэгтийн жагсаалт:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНХО-ын ТАХ-ний жагсаалтад тусгагдсан ТАХ-ний мэдээлэл /тодотгосон төсөв/	9
Хүснэгт 2	ОНХО-ын 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад өөрчлөлт оруулсан мэдээлэл	12
Хүснэгт 3	Орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй ТАХ-ний мэдээлэл	13
Хүснэгт 4	ОНХО-аар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний төрөл	14
Хүснэгт 5	Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн тухай мэдээлэл	15
Хүснэгт 6	2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааны мэдээлэл	16
Хүснэгт 7	ТАХ-ний зураг, төсөвт магадлалын дүгнэлт гаргуулсан судалгаа	18
Хүснэгт 8	Сангийн яамнаас хүчингүй болгосон тендерийн жагсаалт	19
Хүснэгт 9	ОНТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-д олгосон санхүүжилт	19
Хүснэгт 10	Өмнөх онуудад хэрэгжүүлсэн ТАХ-ний өр төлбөрийн мэдээлэл	20
Хүснэгт 11	Тайлант онд хэрэгжээгүй болон дараагийн төсвийн жилд шилжих төсөл арга хэмжээ	23
Хүснэгт 12	Хөрөнгө оруулалтын дансанд байршуулсан Барьцаа хөрөнгийн мэдээлэл	27

Зургийн жагсаалт:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем	7
Зураг 2	Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засварын ажил	8
Зураг 3	Алтанширээ сумын Соёлын төвийн барилгын засварын ажил	8
Зураг 4	Сайншанд сумын "Дорноговьд үйлдвэрлэв" бизнес эрхлэгчдийн төвийн гадна авто зогсоол, тохижилтын ажил	24
Зураг 5	Эрдэнэ сумын ЭМТ-ийн барилгын гадна дулааны ажил	24
Зураг 6	Хатанбулаг сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилга	25
Зураг 7	Хатанбулаг сумын 8 айлын орон сууц барих ажил	25
Зураг 8	Замын-Үүд суманд Өрхийн эмнэлэг барих ажил	26
Зураг 9	Замын-Үүд суманд камерын хяналт, удирдлагын нэгдсэн систем байгуулах ажил	26
Зураг 10	Ханги боомтын ЭМТ-ийн барилга	27
Зураг 11	Замын-Үүд Тохижилт НААҮ ОНӨХХК-ний хог тээврийн шахагч машин	30
Зураг 12	Улаанбадрах суманд дулааны уурын зуух болон тоног төхөөрөмж худалдан авах ажил	30
Зураг 13	Хатанбулаг сумын Соёлын төвд Лед дэлгэц худалдан авах ажил	31
Зураг 14	Замын-Үүд суманд 500 хүний суудалтай Соёл урлагийн ордонд тоног төхөөрөмж худалдан авах	32

Дүрслэлийн жагсаалт:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймгийн ОНХО-аар олгосон санхүүжилт	20
Дүрслэл 2	Замын-Үүд сумын ОНХО-аар олгосон санхүүжилт	20
Дүрслэл 3	Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй ТАХ-ний мэдээлэл	29

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитыг хийсэн.

Аудитын зорилго.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг УИХ болон Үндэсний аудитын газар, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Тус зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагч, харьяа байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагчид, аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ, ХААГ, бусад хамрагдагч байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817- 1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817- 8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашигласан.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлэн, ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Б.Ариунбаатар, М.Оюу-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 1. ОНХО-ААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАХ-НЫ ЖАГСААЛТАД ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ БҮРЭН ХАНГАСАН АЖЛЫГ БАТАЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1.1. Аймаг, Замын-Үүд сумын ИТХ-аар 2023 онд баталсан “ОНХО-аар 2024 онд хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалт”-д нийт 159 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр тусгаснаас аймгийн хөрөнгө оруулалтаар 111, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар 48 ТАХ-г хэрэгжүүлэхээр тус тус баталсан нь аймгийн дунд болон богино хугацаанд баримтлах бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн байна.

1.2. ОНХО-ыг иргэдийн санал, ЭЗ-ийн үр ашиг, нийгмийн ач холбогдолд үндэслэн тооцох төлөвлөлтийн шаардлага бүрэн хангагдаагүй байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад 278 ТАХ батлагдсан ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар байгууллага, иргэдээс ирүүлсэн 170 саналаас 64 саналыг жагсаалтад тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1¹, 29 дүгээр зүйлийн 29^{1.12}-д заасан мэргэжлийн байгууллагаас барилгын ашиглалтын төлөв байдлын талаар дүгнэлт гаргасан, газар хөдлөлт тэсвэршлийн шаардлагыг хангахгүй нь тогтоогдсон дараах барилгуудад их засварын ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн нь төсвийг үр ашигтай төлөвлөх зарчимд нийцээгүй байна. Тухайлбал:

- Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар
- Алтанширээ сумын Соёлын төвийн барилгын засвар
- Сайншанд сумын Усан спорт сургалтын төвийн барилга

Аймгийн ТЕЗ-д харьяа байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын саналыг төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан болон бусад шаардлагад нийцүүлсэн, тухайлбал, төсөлд тусгуулах ТАХ-ний ашиглалт болон бусад холбогдох зардлыг зах зээлийн үнэ, тарифт үндэслэсэн тооцоолол хийгээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг үнэлж эрэмбэлсэн талаар баримт материал ирүүлээгүй байгаа нь төсвийн төлөвлөлтийн зарчмыг баримталж, үр дүнтэй төлөвлөх нөхцөл хангагдаагүй байна.

1.3. Төсвийн тухай хуульд заасан төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан ТАХ-г баталж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад нийт 278 төсөл, арга хэмжээг баталснаас 184 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт№1:ОНХО-ын ТАХ-ний жагсаалтад тусгагдсан ТАХ-ний мэдээлэл /тодотгосон төсөв/

Д/д	Хөрөнгө оруулалтын төрөл	АИТХ-ын 2024 оны 19/01 тогтоолоор батлагдсан ТАХ-ний тоо	Замын-Үүд сумын ИТХ-ын 2024 оны 03/17 тогтоолоор батлагдсан ТАХ-ний тоо	Нийт ТАХ-ний дүн
1	Шинэ хөрөнгө оруулалт	96	72	168
2	Шилжих хөрөнгө оруулалт	9	4	13
3	2023 оны үүссэн өр төлбөр	56	-	56
4	2022 оны үүссэн өр төлбөр	13	-	13
5	Замын сангийн хөрөнгө оруулалт /6-шинэ/	9	-	9
6	Их засварын ажил /10-шинэ/	19	-	19
	Дүн	202	76	278

¹ “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна төсвийн зарчмыг мөрдлөг болгох”

² “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”

ОНХО-аар 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 59 барилга, байгууламж, 52 их засварын ажлын төсөвлөлтийн шаардлага хангасан байдлыг үзэхэд шаардлагад нийцээгүй дараах ТАХ-г хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгаж төлөвлөсөн байна. Үүнд:

Төлөвлөлтийн шаардлагад нийцээгүй ТАХ	Барилгын тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй, техникийн нөхцөл олгогдоогүй.	- Мандах сумын төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байгуулах ажил, /дулаан, ус хангамж/ - Ханги боомтод төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц барих ажил, /дулаан, ус хангамж/ - Хөвсгөл сумын ЕБС-ийн багш ажилчдын байрны 4 айлын орон сууцны барилгад халаалт, цэвэр, бохир усны шугам шинээр хийх ажил, /дулаан хангамж/ - Улаанбадрах суманд Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажил /газрын зөвшөөрөл/
	Барилга, байгууламжийн зураг, төсөлд магадлал хийгээгүй.	- Улаанбадрах суманд Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажил, - Усан спорт сургалтын төвийн дээвэр, дотор засал, агаар сэлгэлтийн засварын ажил.
	Төсвийн тухай хуульд заасан шаардлага хангасан ТАХ-г Хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгана гэж заасантай нийцээгүй.	22 ТАХ-ний зураг төсөв, 15 ТАХ-ний магадлалын дүгнэлт, 12 ТАХ-ний техникийн нөхцөл төсвийн санал хүргэгдсэнээс хойш хугацаанд олгогдсон байна.
	Төсвийн тухай хуульд заасан авлага, өр төлбөр үүсгэхгүй байх шаардлагыг хангаагүй.	ОНХО-аар 2022 онд үүссэн 15 ТАХ-ний санхүүжилтийн өр 10,439.0 сая төгрөг, 2023 онд үүссэн 45 ТАХ-ний 4,041.6 сая төгрөгийн санхүүжилтийн өрийг 2024 оны төсөв батлах тогтоолын ТАХ-ны жагсаалтад тусгаж батлаагүй, тодотголоор нэмж тусгасан.
	Тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх” гэсэн заалтад нийцүүлж төлөвлөөгүй.	- Аймгийн ИТХ-ын 2024.07.31-ний өдрийн 18/07 тогтоолоор 2,908.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ний санхүүжилтийг жагсаалтаас хассан, - Аймгийн ИТХ-ын 2024.09.23-ны өдрийн 19/01 тогтоолоор 407.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний санхүүжилтийг жагсаалтаас хассан, - Замын-Үүд сумын ИТХ-ын 2024.08.02-ны өдрийн 15/89 тогтоолоор 1,891.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-г жагсаалтаас хасаж, 6 ТАХ-ний 2024 онд олгох санхүүжилтийг 194.5 сая төгрөгөөр бууруулсан, - Замын-Үүд сумын ИТХ-ын 2024.09.25-ны өдрийн 16/93 тогтоолоор 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний санхүүжилтийг жагсаалтаас хассан, - Замын-Үүд сумын ИТХ-ын 2024.12.19-ний өдрийн 03/17 тогтоолоор 386.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-ний санхүүжилтийг жагсаалтаас хасаж, 2 ТАХ-ний 2024 онд олгох санхүүжилтийг 83.5 сая төгрөгөөр бууруулсан.
	Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн	- Аймгийн ИТХ-ын 2024.07.31-ний өдрийн 18/07 “Дорноговь аймгийн 2024 оны ОНХО-аар хийгдэх ТАХ-ний жагсаалтад өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор шинээр хэрэгжүүлэх 2,908.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-ний санхүүжилтийг нэмж өөрчилсөн байна. - Замын-Үүд сумын ИТХ-ын 2024.08.02-ны өдрийн 15/89 тогтоолоор 469.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-г нэмж зохицуулсан. - Замын-Үүд сумын ИТХ-ын 2024.12.19-ний өдрийн 03/17 тогтоолоор 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г нэмж зохицуулсан.

заалтад нийцүүлж төлөвлөөгүй.

Захиалагч батлагдсан төсөвт тусгасан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэсэн заалтад нийцүүлж төлөвлөөгүй.

- Аймгийн ХО-ын ТАХ-ний жагсаалтад аймгийн төвийн зарим төрийн байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж нийтүүлэх ажил /100.0 сая төгрөг/, хөгжим аппаратур, тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг худалдан авах /298.5 сая төгрөг/, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв гүйцэтгэх зардал /1,000.0 сая төгрөг/,
- Замын-Үүд сумын ХО-ын ТАХ-ний жагсаалтад төрийн зарим байгууллагын автомашины парк шинэчлэлийн ажил /400.0 сая төгрөг/-ыг багц болгон төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад холбогдох хууль, тогтоомжид заасан төлөвлөлтийн шаардлага хангаагүй 39 ТАХ-г төлөвлөж, баталсан байна. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ны жагсаалтад хуулийн шаардлагад нийцсэн ажлыг тусгаж төлөвлөх, төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөхгүй байх гэсэн зарчмыг баримтлаагүйгээс ТАХ-г хэрэгжүүлэх явцад ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орох, гэрээний хугацаанд хэрэгжихгүй сунгагдах, төсөвт өртөг нэмэгдэх, ажил чанаргүй хийгдэх зэрэг нөхцөл үүсэж, зөрчил гарсан байна.

1.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр орон нутгийн өмчлөлд шилжих боломжгүй 3,700.8 сая төгрөгийн 36 ТАХ-г төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 92,468.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 192 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан ба аймгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад 2 удаа, Замын-Үүд суманд 4 удаа зохицуулалт, тодотгол хийж, 120,009.6 сая төгрөгийн 278 ТАХ хэрэгжүүлэхээр өөрчлөлт оруулж баталсан байна.

Хүснэгт №2. ОНХО-ын 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад өөрчлөлт оруулсан мэдээлэл

/сая төгрөг/									
Төсөв захирагч	Анх батлагдсан төсөл, арга хэмжээ			Тодотгож баталсан төсөл, арга хэмжээ			Өөрчлөлт		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Аймаг	141	80,852.0	42,084.7	202	106,741.1	45,938.9	61	25,889.1	3,854.0
Замын-Үүд сум	51	11,616.9	6,875.9	76	13,268.5	9,047.5	25	1,651.6	2,171.6
Нийт	192	92,468.9	48,960.6	278	120,009.6	54,986.4	86	27,540.7	6,025.8

Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бодитой тооцохгүй, шинэ ТАХ-хэрэгжүүлэхээр тодотгож баталсан нь өмнө оноос шилжин хэрэгжсэн болон шинээр хэрэгжүүлж дууссан ТАХ-ний санхүүжилтийг бүрэн олгохгүй, хөрөнгө оруулалтын өр нэмж үүсэх нөхцөлийг үүсгэсэн байна.

Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтын төлөвлөлт	ОНХО-аар 20.0 хүртэл сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 ТАХ-д 684.4 сая төгрөгийг, 7 ТАХ-ний зураг төсвийн зардалд 164.9 сая төгрөг, нийтийн орон сууцны засварт 491.6 сая төгрөг, төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлэгч ГИХГазар, Гаалийн газар, ХЦ-ийн ангийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд 2,841.0 сая төгрөг, 6 байгууллагын хэрэгцээнд 987.7 сая төгрөгийн автомашин нийлүүлэхээр, нийт батлагдсан төсвийн 57.1 хувь буюу дээр дурдсан 63 ТАХ-ний санхүүжилтэд 5,169.6 сая төгрөгийг төлөвлөсөн.
--	--

Хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр сум орон нутагт нэн тэргүүнд шаардлагатай, үр дүнтэй томоохон ажлыг төлөвлөх бус харин байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг жигд шийдвэрлэхэд чиглэж төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24³, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2⁴ заасан шаардлагыг хангаагүй төлөвлөж 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ-ний жагсаалтад аймгийн хөрөнгө оруулалтаар 1,752.3 сая төгрөгийн 10, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар 1,948.5 сая төгрөгийн 26, нийт хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, орон нутгийн хөрөнгөд бүртгэх боломжгүй 3,700.8 сая төгрөгийн 36 ТАХ-г баталсан байна.

Хүснэгт№3. Орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй ТАХ-ний мэдээлэл

			/сая төгрөг/
№	ОНХО	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	Аймгийн ОНХО	10	1,752.2
2	Замын-Үүд сумын ОНХО	26	1,948.5
Нийт		36	3,700.8

Шийдвэрлэлт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын шинж чанартай, ашиглагч байгууллагын данс бүртгэлд бүртгэх боломжтой ТАХ-г төлөвлөх талаар аймгийн Засаг дарга, Замын-Үүд сумын засаг дарга нарт албан шаардлага хүргүүлсэн.

Аймаг, Замын-Үүд сумын ИТХ нь хөрөнгө оруулалтын төсвийг хэлэлцэж батлахдаа улс, орон нутгийн бодлого, шийдвэртэй уялдсан байдал, холбогдох хууль, журмын шаардлагад нийцсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөсөн байдлыг харгалзахгүй баталснаас хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой зөрчил давтагдан гарсан байна.

Шийдвэрлэлт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад төлөвлөлтийн шаардлага хангасан, бусад хууль, журамд нийцсэн, аймаг орон нутгийн хэрэгцээнд нэн шаардлагатай байгаа томоохон ТАХ-г тусгагдсан эсэхийг хэлэлцэж батлах, хуулиар олгосон эрх, үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар аймаг, Замын-Үүд сумын ИТХ-д албан шаардлага хүргүүлсэн.

ОНХО-ын ТАХ-д тусгагдсан сумдын дэд бүтцийг сайжруулах, цахилгаан, дулааны шугам сүлжээ, орчны тохижилт, төсөл хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулах, хүн малын усан хангамж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг бусад холбоотой хууль, журмын зорилготой уялдуулан нийцүүлж сумын ОНХС, малын тоо толгойн албан татварын орлого, хөтөлбөр арга хэмжээний зардлаас хэрэгжүүлэхээр төлөвлөх, энэ талаар аймгийн ТЭЗ-аас сумдын удирдлагуудыг чиглүүлснээр ОНХО-аар томоохон ТАХ-г төлөвлөн хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг үр дүнтэй зарцуулах боломж бүрдэхээр байна.

2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. ТЭЗ зарим ТАХ-ний тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг хуульд заасан хугацаанд шилжүүлээгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд нийт 278 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр, үүнээс 184 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр тодотгож баталсан байна.

³ “Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага”

⁴ “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээг тусгахыг хориглоно”

Хүснэгт №4. ОНХО-аар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний төрөл

Д/д	Хөрөнгө оруулалтын төрөл	Аймгийн ХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо	Замын-Үүд сумын ХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо	Нийт ТАХ-ний дүн
1	Барилга, байгууламж	39	11	50
2	Их засвар, засвар	38	23	61
3	ТЭЗҮ	5	9	14
4	Тоног төхөөрөмж	30	29	59
5	Өмнөх оноос шилжсэн	11	4	15
6	2023 оноос өр үүссэн	65	-	65
7	2022 оноос өр үүссэн	14	-	14
	Дүн	202	76	278

Дорноговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 16,213.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 67 ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах эрхийг сумдын ТТЗ болон ашиглагч байгууллагад шилжүүлсэн байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1 “Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргад үндэслэн зохион байгуулна” гэсэн заалтын дагуу ОНХО-аар 2024 онд 85 ТАХ-ний нээлттэй тендер шалгаруулалт, 31 харьцуулалтын арга, шууд гэрээ байгуулах 38, зэвсэгт хүчин, хилийн цэргийн ангиудад эрх шилжүүлсэн 8, нууцын зэрэглэлтэй 2 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Засгийн газрын 2023 оны 278 тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1⁵-т заасныг зөрчиж аймгийн Засаг даргаас 5 ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах эрхийг 4 сумын ТТЗ-д 2024 оны 08 дугаар сараас хойш хугацаанд шилжүүлсэн байна.

Барилга байгууламж шинээр барих зарим ТАХ-г төсвийн тодотголоор нэмж 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөж батлан, сумдын ТТЗ-д захиалагчийг сонгон шалгаруулах эрх шилжүүлснээс шалтгаалан төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй ТАХ-ний мэдээлэл:

- Сайншанд сумын Алтанговийн III гудамж, 12 худалдаа үйлчилгээний төвөөс Дүүдээ баатар-6 гудамж хүртэл автозам дагуу явган хүний зам хийх ажил /180.0 сая төгрөг/,
- Улаанбадрах сумын төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажил /480.0 сая төгрөг/,
- Аймгийн төвийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын ажилчдын байр барих ажил /200.0 сая төгрөг/

2.2. Сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн ТАХ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийг баримтлан ОНХО-аар хэрэгжүүлэх 165 ТАХ-ний 157 тендер шалгаруулалтыг зохион байгуулж, нийт 197 удаагийн тендерийг tender.gov.mn худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй ил тод байдлаар зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Төсөв захирагч	Худалдан авах ажиллагааны төрөл	Төсөл, арга хэмжээний	Шалгаруулсан
Аймаг	Нээлттэй тендер шалгаруулалт	67	62
	Харьцуулалт арга	21	19
	Шууд гэрээ байгуулсан	3	3
	Бусад/төрийн нууцад хамаарах/	9	9
Замын-Үүд сум	Нээлттэй тендер шалгаруулалт	15	14
	Харьцуулалт арга	10	10
	Шууд гэрээ байгуулах	40	40
	Нийт	165	157

ОНХО-аар шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 112 ТАХ-ээс 16,718.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 67 ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах эрхийг аймгийн Засаг даргаас 14 сумын засаг дарга, 3 байгууллагад шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.

5 “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна”

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.5⁶-д заасныг зөрчиж шууд худалдан авалт зохион байгуулсан ТАХ-ний мэдээлэл. Үүнд:

- Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан тус сумын ЕС-ын II, III сургууль, хотын ЗАА, сумын ЗДТГ-ын хэрэгцээнд 76.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийтийн тээврийн автобус худалдан авах ажлыг 4 ТАХ болгон тусгаж баталсан ба техникийн тодорхойлолт боловсруулахгүй шууд худалдан авалт хийсэн,
- Замын-Үүд сумын 5 багийн нутаг дэвсгэрт байрлах ус түгээх байруудад автоматжуулалт хийх 55.0 сая төгрөгийн ажлын төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг мөрдөөгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх шаардлагыг хангасан байх” гэж заасныг зөрчин зураг, төсвийн магадлалын дүгнэлт гараагүй 45,306.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-ний тендерийг зарласан байна.

Хүснэгт№5. ТАХ-ний зураг, төсөвт магадлалын дүгнэлт гаргуулсан судалгаа /сая төгрөг/

Д/д	УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний нэр	Магадлалын дүгнэлтийн огноо	Тендерийн урилга нийтэлсэн огноо	Магадалсан төсвийн дүн	ТАХ-ний жагсаалтад батлагдсан төсөвт өртөг
1	Дэлгэрэх суманд ТАХ-ийн 6 айлын орон сууцны барилга барих ажил	2024.12.13	2024.07.30	621.3	609.3
2	Улаанбадрах суманд ТАХ-ийн 6 айлын орон сууцны барилга барих ажил	-	2024.07.22	-	480.0
3	Алтанширээ сумын Соёлын төвийн засварын ажил	2024.02.28	2024.02.26	452.8	452.0
4	Эрдэнэ сумын ЭМТ-ийн барилгын гадна дулааны ажил	2025.05.03	2024.04.17	704.0	548.4

Төсөвт өртгийг магадлалаар баталгаажсан төсвийн дүнд үндэслэхгүйгээр ТАХ-г төлөвлөн, баталж хэрэгжүүлснээр нэмэлт гэрээ байгуулах, ажил чанаргүй, дутуу хийхэд нөлөөлсөн байна.

Шийдвэрлэлт

Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахтай холбоотой зөрчил өмнөх аудитаар илэрч зөвлөмж өгсөн боловч зөрчил давтагдан гарсан тул холбогдох журмын дагуу “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” нийцлийн аудитаар албан шаардлага өгч шийдвэрлэсэн болно.

2.3. ХАА-ны хууль, журам, тендерийн баримт бичигт заасан шалгуурын дагуу үнэлээгүйгээс зарим төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт цуцлагдсан байна.

Худалдан авах ажиллагааны газраас аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 37 ТАХ-ний тендерийг зарласнаас 9 ТАХ оролцогчгүй, ТББ шаардлага хангаагүй, гэрээ байгуулахаас татгалзсан шалтгаанаар хүчингүй болж, 10 ТАХ-ний тендерийг 2-4 удаа зарласан байна.

Хүснэгт№6. Сангийн яамнаас хүчингүй болгосон тендерийн жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Тендер зарласан огноо	Тендерт шалгарсан компанийн мэдээлэл
1	Хөвсгөл сумын ЕБС-ийн өргөтгөл барих, хуучин сургуулийн гадна фасад засварын ажил	2024.04.15	"Хөх оноо" ХХК "Хөх оноо" ХХК

⁶“ босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор төсөвт өртгийг хувааж тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн			
2	Сайншанд сумын суурьшлын хэсгийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажил	2024.03.19	"Агар од инженеринг"
3	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажил	2024.03.20	"Лапланд эко" ХХК "Лапланд эко" ХХК
4	700 хүний суудалтай Саранхөхөө театрт тоног төхөөрөмж худалдан авах ажил	2024.06.11 2024.08.05 2024.10.14	"Киберком" ХХК "Киберком" ХХК
5	Эрдэнэ сумын ЭМТ-ийн барилгын гадна дулааны ажил	2024.05.13	"Түрүү гарав" ХХК "Жи Би Ти Эм Би" ХХК
6	Хүүхдийн парк руу автозам тавьж зогсоол байгуулах ажил	2024.05.13	"Силк трасс" ХХК
7	Сайншанд 7-р баг "Гор газ" ШТС-ын уулзвараас баруун тийш үргэлжлэх 1.59 км автозам гэрэлтүүлэг хийх ажил	2024.04.30	"Уртын-Уул" ХХК "Чандманьхонгор групп" ХХК
8	Сайншанд сумын ЗАА-д 5 ширхэг хог ачилтын автомашин худалдан авах ажил	2024.02.16 2024.05.31	Альянстрейд ХХК Эй эй юу ХХК

ОНХО-аар хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцогч 8 аж ахуйн нэгж, байгууллага тендер шалгаруулалтын үр дүнтэй холбоотой гомдол гаргаж, Сангийн яамнаас гомдлыг хянан, захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгож, 3 тендер шалгаруулалтыг дахин зарласан байна.

Шийдвэрлэлт	Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын тендер шалгаруулалттай холбоотой дээрх зөрчилд "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" нийцлийн аудитаар зөвлөмж өгсөн болно.
--------------------	--

3. ОНХО-ААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ ДАВТАГДАН ГАРСАН БАЙНА.

3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэхгүй олгосон зөрчил давтагдсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 278 ТАХ-ээс 237 ТАХ-г гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлсэн ба 232 ажлын санхүүжилтэд нийт 40,006.4 сая төгрөгийг олгосон байна.

Хүснэгт №7. ОНТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-д олгосон санхүүжилт /сая төгрөг/

Төсөв захирагч	Төлөвлөлтийн ангилал	Хэрэгжсэн ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжүүлэх дүн	Олгосон санхүүжилтийн дүн
Аймаг	Шинэ	97	46,793.1	44,839.6	24,806.4
	2023 оноос шилжих	11	12,186.6	11,517.0	2,103.5
	2023 оны өр төлбөр	41	20,438.5	19,760.7	5,061.3
	2022 оны өр төлбөр	10	13,870.7	13,356.1	892.5
	Дүн	159	93,288.9	89,473.4	32,863.7
Замын-Үүд сум	Шинэ	69	11,885.30	11,474.20	6812.4
	2023 оноос шилжих	4	980.7	929.2	330.3
	Дүн	73	12,866.0	12,403.4	7,142.7
Нийт дүн		232	106,154.9	101,876.8	40,006.4

Аймаг болон Замын-Үүд сумын ХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний санхүүжилт болон хөрөнгө оруулалтын төрлийг харьцуулж авч үзвэл дараах байдалтай байна.

ОНТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-д олгосон санхүүжилт /ТАХ-ний ангиллаар/

Дүрслэл№1

Дүрслэл№2

АЙМГИЙН ОНХО-ААР ОЛГОСОН
САНХҮҮЖИЛТ /САЯ ТӨГРӨГ/ЗАМЫН-ҮҮД ОНХО-ААР ОЛГОСОН
САНХҮҮЖИЛТ /САЯ ТӨГРӨГ/

Хүснэгт№8. Өмнөх онуудад хэрэгжүүлсэн ТАХ-ний өр төлбөрийн мэдээлэл /сая төгрөг/

Төсөв захирагч	Төлөвлөлт	Батлагдсан ТАХ-ний тоо	2024 онд санхүүжүүлэх дүн	Санхүүжилт олгосон ТАХ-ний тоо	Олгосон санхүүжилт	Өмнө онуудын ХО-ын өр төлбөрийн үлдэгдэл
Аймаг	2023 оны өр төлбөр	65	6,728.8	41	5061.3	39
	2022 оны өр төлбөр	14	1,172.4	10	892.5	13
	Нийт дүн	79	7,901.2	51	5,953.8	51

2025 онд
дахин
төлөвлөх

Өмнө онуудад үүссэн 79 ТАХ-ний санхүүжилтийн өр 7,901.2 сая төгрөгөөс 2024 онд 51 ТАХ-ний 5,953.8 сая төгрөгийн өрийг гүйцэтгэгч компаниудад шилжүүлэн 28 ТАХ-ний өрийг бүрэн барагдуулж, оны эцсийн байдлаар 51 ТАХ-ний 1,947.4 сая төгрөгийн өрийн үлдэгдлийг дахин төлөвлөхөөр байна.

Аймгийн ОНХО-аар өмнөх онуудад хэрэгжүүлсэн 7 ТАХ-ний материалын үнийн зөрүү, нэмэлт ажлын санхүүжилтийг 2024 оны ТАХ-ны жагсаалтад баталж 2,975.1 сая төгрөгийг олгосон байна. Үүнд:

Материалын
үнийн зөрүү,
нэмэлт ажилд
олгосон
санхүүжилт

- Замын-Үүд сумын 1-р багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилгын материалын үнийн нэмэгдэл 198.0 сая төгрөг
- Замын-Үүд сумын 640 хүүхдийн сургуулийн барилгын ажлын материалын үнийн нэмэгдэл 1,800.0 сая төгрөг
- Хөвсгөл сумын төвлөрсөн шугам сүлжээний гадна цахилгаан хангамжийн ажлын материалын үнийн нэмэгдэл 895.7 сая төгрөг
- Сайншанд сумын 3 дугаар багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилгын материалын үнийн нэмэгдэл 221.1 сая төгрөг

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6⁸, Засгийн газрын 2023 оны 258 дугаар тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8.38.3⁹-т заасныг зөрчин зураг төсвийн дагуу

⁷ “Тухайн шатны Засаг дарга төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ТАХ-ний нийт саналыг шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа ТАХ, их засвар, засвар арчлалт, шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ гэсэн эрэмбийг баримтлан жилийн төсвийн төсөлд тусгана”

⁸ “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”

⁹ “Санхүүжилтийн зохицуулалтыг тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэн олгох шаардлагыг хангасан байна”

бүрэн хийгдээгүй болон техникийн тодорхойлолтод тусгасан шаардлагыг хангаагүй тоног төхөөрөмжийг хүлээн авч, гүйцэтгэлд үндэслэхгүй санхүүжилт олгосон байна. Үүнд:

Төсөл, арга хэмжээ	Баталгаажуулсан %	Олгосон %
Улаанбадрах суманд төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажил	70.0	80.0
"Дорноговьд үйлдвэрлэв-бизнес эрхлэгчдийн төвийн гадна авто зогсоол, тохижилтын ажил"	100.0	91.5

Аймгийн ХО-аар Хатанбулаг сумын Соёлын төвд лед дэлгэц худалдан авах ажлын 20.9 сая төгрөг, Хөвсгөл сумын ЕБС-ийн багш ажилчдын байрны 4 айлын орон сууцны барилгын халаалт, цэвэр, бохир усны шугам шинээр хийх ажлын зураг төсвийн 4.4 сая төгрөг, нийт 25.3 сая төгрөгийн санхүүжилтийг ОНХС-аас шилжүүлсэн зөрчлийг 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өглөгөөр тусгуулж шийдвэрлэсэн байна.

ОНХО-ын төсвийг төлөвлөх, төсвийн зохицуулалт, нэмэлт өөрчлөлтөөр ТАХ-ний хэрэгцээ шаардлага, хэрэгжих хугацаа, бусад хүчин зүйлсийг харгалзан, нэн тэргүүнд шаардлагатай ажлыг төлөвлөж батлуулснаар өмнө онуудад үүссэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн өр төлбөрийг барагдуулах боломж байна.

3.2. ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний ажил гүйцэтгэх гэрээний хугацааг ажлын тоо хэмжээ болон бусад хүчин зүйлстэй уялдуулан бүрэн хэрэгжүүлэх хугацаагаар төлөвлөж, батлах шаардлагатай байна.

Сангийн сайдын 2023 оны А/259 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн зааварчилгаа"-ны 4.1¹⁰, 4.4¹¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4¹²-т заасныг баримтлаагүй аймаг, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 184, өмнөх оноос шилжиж хэрэгжих 15, нийт 199 ТАХ-ээс 2024 онд 164 ажлыг хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөж, 151 ТАХ-г гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлж, 13 ажил төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна.

Хүснэгт №9. Тайлант онд хэрэгжээгүй болон дараагийн төсвийн жилд шилжих төсөл арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Тайлбар
1	Улаанбадрах суманд Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажил	2024	2024	2024.09.11-2025.05.01-ний хооронд гүйцэтгүүлэхээр гэрээ сунгасан
2	Дорноговьд үйлдвэрлэв бизнес эрхлэгчдийн төвийн гадна авто зогсоол, тохижилтын ажил	2024	2024	
3	Аймгийн төвийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын ажилчдын байр барих ажил	2024	2024	Гэрээний хугацаа дууссан
4	Сайншанд суманд камерын хяналт, удирдлагын нэгдсэн систем байгуулах болон нэмэлт ажил	2024	2024	
5	Алтанговийн 3 дугаар гудамж "12 Худалдаа" үйлчилгээний төвөөс Дүүдэй баатар-6 гудамж хүртэл авто зам дагуу явган хүний зам хийх ажил	2024	2024	Тендерийг 12 сард нээж Айсуу хөгжил ХХК шалгарсан, гэрээг 2025 оны 01 дүгээр сард байгуулсан. /2024.11.05/
6	Барилга байгууламжийг паспортжуулах ажил	2024	2024	2025.01.13-нд гэрээ байгуулсан. /2024.02.15, 2024.10.16, 2024.11.13/
7	Дэлгэрэх суманд Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажил	2024	2024	2024.11.09-2025.03.25-ны хооронд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. /2024.07.30, 2024.09.06, 2024.10.08/
8	Замын-Үүд суманд Хүүхэд хөгжлийн төвийн барилга барих ажил	2024	2024	Нууцын объект

¹⁰ "Гүйцэтгэгч ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал, захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй, захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно"

¹¹ "Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно"

¹² "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх гэсэн журмыг баримтална"

9	Хилийн 0108 дугаар ангийн 22 айлын ажилчдын орон сууц барих ажил /Замын-Үүд ХО/	2024	2024	
10	АЗДТГ-т бага оврын автобус худалдан авах ажил	2024	2024	Тендер цуцлагдсан
11	Гандантэгчилэн хийдийн орчны тохижилт	2024	2024	
12	2 уурын зуух буулгах ажил /Замын-Үүд ХО/	2024	2024	Хэрэгжээгүй
13	Хүнд даацын 2.1 км автозамын зураг төсөв /Замын-Үүд ХО/	2024	2024	

Аймаг, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтын төсвийг 07, 10, 12 дугаар саруудад тодотгож, нэмэлтээр 80 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан нь ТАХ-ний тендер зарлах болон гэрээ байгуулах хугацаа оройтож, төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэх боломжгүй, дараагийн төсвийн жилд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байна.

Гэрээний хугацаанд хэрэгжүүлээгүй 3 ажилд 91.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

- Сайншанд сумын "Дорноговьд үйлдвэрлэл" бизнес эрхлэгчдийн төвийн гадна авто зогсоол, тохижилтын ажил-3.3 сая төгрөг,
- Сайншанд суманд камерын хяналт, удирдлагын нэгдсэн систем байгуулах болон нэмэлт ажил- 33.2 сая төгрөг
- Эрдэнэ сумын ЭМТ-ийн барилгын гадна дулааны ажил- 55.4 сая төгрөг

Аймгийн төвийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын ажилчдын байр барих 200.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг 2024.06.06-2024.07.26-ны хооронд хэрэгжүүлэхээр Чандмань-Илч ОНӨХХК-д эрх шилжүүлж "Локи интернешнл" ХХК-тай гэрээ байгуулсан ба 50 хувийн гүйцэтгэлд 100.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэгч компани ТАХ-г бүрэн хэрэгжүүлж хүлээлгэн өгөх гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчлийг шийдүүлэхээр аймгийн Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна.

3.3. Зураг, төсвийн дагуу хийгдээгүй, бүрэн хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1¹³, МУ-ын Иргэний тухай хуулийн 350.1¹⁴, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 8.2.1¹⁵-д заасны дагуу барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэхээр байхад зөвлөмж бүрэн биелэгдсэн байдалд хяналт тавиагүй, зураг, төсвийн дагуу бүрэн хийгдээгүй дараах ТАХ-г ашиглалтад хүлээн авсан байна. Үүнд:

¹³ "Барилга байгууламж нь зураг төслийн дагуу баригдсан байх"

¹⁴ "Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх үүрэг хүлээж, захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх"

¹⁵ "Барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргана", 8.2.2 "Энэ дүрмийн 5.1, 6.1-т заасан шаардлага хангаагүй, 8.1-т заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт өгнө"

- Хатанбулаг сумын ЭМТ-ийн өртөгтөлийн 1,249.2 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Энержипарагон ХХК 2023.08.16-2024.06.01-ний хугацаанд гүйцэтгэж, 2024.07.03-ны өдрийн УҚД-12/2024 комиссын актаар байнгын ашиглалтад хүлээж авсан боловч лаборатори болон ариутгалын өрөөний цонх, хаалганы битүүмж муугаас шороо, ус орж тоног төхөөрөмж байрлуулах боломжгүй байдалтай,
- Хатанбулаг сумын 8 айлын орон сууц барих 832.3 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Өнгөт харш ХХК гүйцэтгэж, 2024.09.24-ний өдрийн УҚД-15/2024 комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан боловч барилгын цонх, хаалгаар салхи сийгдэг, дулаан алдагдалтай, үерийн далан хамгаалалт хийгдээгүйгээс орцны хаалгаар борооны ус урсаж 1 дүгээр давхарт байрлах цахилгаан үүсгүүрт гэмтэл, доголдол үүсэх нөхцөл бүрдсэн,
- Сайншанд сумын 1 дүгээр багт тоглоомын талбай барих 74.3 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Айсуй хөгжил ХХК гүйцэтгэж, 2024.09.23-ны өдрийн ГТ-01/2024 актаар хүлээн авсан боловч хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлын төсөвт тусгагдсан 23.5м² резин хавтангаас 17.5м² дутуу хийсэн, модон тавцантай төмөр хөлтэй 4 ширхэг сандлыг суурилуулаагүй,
- Замын-Үүд дэх сум дундын Прокурорын газарт 35.0 сая төгрөгийн өртөгтэй автомашин худалдаж авах: Техникийн тодорхойлолтод үйлдвэрлэсэн он 2015 оноос хойш байхаар тусгасан байхад 2014 он үйлдвэрлэсэн Toyota prius-30 маркийн автомашиныг хүлээж авсан,
- Өргөн сумын Соёлын төвд хөгжим хэрэгсэл худалдан авах 99.9 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2024.04.11-2024.06.14-ний хугацаанд СИТИ ЛЕД ХХК гүйцэтгэх гэрээ байгуулж, 2024.06.13-ны өдөр гэрээний дагуу бүрэн нийлүүлсэн тухай комиссын акт үйлдэн хүлээн авсан байх боловч 2 хөгжмийн зэмсгийг дутуу нийлүүлсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон,
- Замын-Үүд суманд байршилтай Өрхийн эмнэлэг барих 950.1 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Төгс өнөд ХХК гүйцэтгэж, 2024.06.24-ний өдрийн УҚД-11/2024 комиссын дүгнэлтээр ашиглалтад хүлээж авсан боловч Борхойн наран ӨЭМТ-ийн барилгын цонхны дулаалга муу хийгдсэнээс шороо, борооны ус нэвтэрч зарим тавилгын чанарыг муутгасан, сургалтын өрөөн салхивчгүй, агааржуулалтын хоолойгоор салхи үлээж, шороо ордог, лабораторийн өрөөний плита ховхорсон зэрэг эвдрэлийг засварлуулахаар гүйцэтгэгч компанид хандсан боловч доголдлыг арилгаагүй,
- Замын-Үүд суманд камерын хяналт, удирдлагын нэгдсэн систем байгуулах 750.0 сая төгрөгийн өртөгтэй ажил бүрэн дуусаагүй байхад ашиглалтад хүлээн авсан ба камерын өндрийн стандарт хангагдаагүй, дүрсний ялгарал муу, хүний царай, автомашины дугаар таних боломжгүй,
- Ханги боомтын ЭМТ-ийн 1,990.2 сая төгрөгийн өртөгтэй барилгын ажлыг Энержи парагон ХХК гүйцэтгэж, 2023.12.22-ны өдрийн УҚД-15/2023 актаар ашиглалтад хүлээн авсан боловч цонхоор шороо, агааржуулалтын хоолойгоор ус нэвтэрдэг, агааржуулалтын систем бүрэн ажиллахгүйгээс бохир үнэртдэг, ундны усны эх үүсвэр нь эрүүл ахуйн шаардлага хангагдаагүйгээс өвчтөн хэвтүүлэх боломжгүй, барилгыг бүрэн хүчин чадлаар ашиглах нөхцөл бүрдээгүй,
- Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт камержуулалт нэмэгдүүлэх 274.6 сая төгрөгийн өртөгтэй ажлын газар шорооны ажил, кабель холбох ажил хийгдээгүй байхад 2024.12.15-ны өдөр ашиглалтад хүлээн авсан байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс зураг, төсвийн дагуу бүрэн, чанартай хэрэгжээгүй ТАХ-г ашиглалтад хүлээн авч хууль заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс чанаргүй ажлууд хийгдэж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг үр дүнгүй зарцуулах, цаашлаад ашиглагч байгууллагын урсгал зардал нэмэгдэх нөхцөлийг үүсгэж байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.6¹⁶-д заасны дагуу аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд нийт 12 ажлын 771.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Хүснэгт№10

№	Төсөл арга хэмжээний нэр	Төвлөрүүлсэн дүн /сая төгрөг/
1	Ханги боомтын ЭМТ-ийн барилга	98.7
2	Замын-Үүд сумын 1-р багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилга	39.8
3	Саран хөхөө театр, "Мандах наран-5" орон сууцны хорооллын гадна цахилгаан хангамж, дэд станц барих ажил	31.1
4	Улаанбадрах сумын нэгдсэн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ нэмж татах ажил	40.8
5	Сайншанд сумын 7 дугаар багт Дулааны эх үүсвэр барих	187.7
6	Сайншанд суманд шинээр баригдах Мандах наран хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил	198.1
7	Саран хөхөө театр, "Мандах наран-5" орон сууцны хорооллын гадна дулаан, цэвэр ус, бохир усны шугам сүлжээний ажил	117.6
8	Айраг сумын ЭМТ-ийн 1-р байрны засвар хийх ажил	17.0
9	Айраг сумын Дулааны станцын 3-р зуух шинэчлэлийн ажил	6.7
10	Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн урд авто зам, Зүүн буянт ухаа, Дунд буянт ухаа гудамжны дундуур зүүн чиглэлийн авто замын дагуу гэрэлтүүлэг хийх ажил	6.1
11	Сайншанд сумын 4,7-р баг, арын 3-н замын уулзвараас төмөр замын гарам хүртэл 2.1 км автозамд гэрэлтүүлэг хийх ажил	15.9
12	Сайншанд 7-р баг "Гор газ" ШТС-ын уулзвараас баруун тийш үргэлжлэх 1.59 км автозам барих ажил	11.8
Нийт дүн		771.4

¹⁶ "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно"

ОНХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний тодорхой хэсгийг чанаргүй хийгдсэн ажлууд эзэлж байгаа ба зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгч компаниуд чанаргүй гүйцэтгэсэн ажлыг хуульд заасны дагуу засварлах үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1¹⁷-д заасны дагуу ОНХО-аар 2024 онд хэрэгжүүлэх ТАХ-ний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга ГХБХБГ-тай захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, 30 ТАХ-ний гүйцэтгэлд тус албаны 1 мэргэжилтэн, гэрээт 3 инженер, нийт 4 ажилтан ОНХО, УТХО, ОНХС, бусад эх үүсвэрээр орон нутагт хийгдсэн ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, 140.6 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг олгосон байна.

Орон нутагт захиалагчийн хяналт хэрэгжүүлэх ажилтны тоо цөөн, хяналт тавих ажлын тоо олон, хяналт хэрэгжүүлэх ТАХ-ний байршил алслагдсан зэрэг нөхцөл байдал нь захиалагчийн хяналтыг чанартай, хүртээмжтэй хэрэгжүүлэхэд нөлөөлсөн байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажилд зураг, төсөв зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1¹⁸-д заасны дагуу ОНХО-аар хэрэгжүүлсэн 40 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд зохиогчийн хяналт хэрэгжүүлэх гэрээ байгуулж, 25 ажлын хяналтын зардалд 62.1 сая төгрөгийг олгосон байна.

ОНХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний зураг, төсөв зохиог ААНБ-ууд Улаанбаатар хотын харьяалалтай компани байдгаас зарим тохиолдолд үе шатны хяналтыг тухай бүр хийх боломжгүй, ил, далд ажлын актыг бодит байдалд үндэслэж баталгаажуулахгүй, ашиглалтад хүлээж авах комисст дүгнэлт гаргаж санхүүжилт авах нөхцөл үүсдэг, үүнээс шалтгаалан гүйцэтгэгч компани үе шатны ажлыг зураг, төсвийн дагуу чанартай хийхгүй байх эрсдэл үүсэхээр байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1¹⁹-д заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт шалгалт хийх ажлыг тусгаж батлаагүй, дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах эрхийг сумдын Засаг дарга, ашиглагч байгууллагад шилжүүлэн хэрэгжүүлсэн нь худалдан авах ажиллагааг зохион байгуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлтэй холбоотой зөрчил гарсан байна.

Орон нутгийн мэргэжлийн байгууллагуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд хөрөнгө оруулалтын ажилд хяналт хэрэгжүүлээгүйгээс ОНХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой зөрчил буураагүй байна.

3.4. Бүрэн хэрэгжиж дууссан 10,912.5 сая төгрөгийн өртөгтэй 53 ТАХ-г ашиглагч байгууллагын НББ-д тусгаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т “Хөрөнгө оруулалтыг тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага байна” гэж тодорхойлсон.

¹⁷ “Аймгийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавина”

¹⁸ “Зураг, төсөв зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина”

¹⁹ “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2²⁰, 78.2.4²¹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2²² тус тус заасны дагуу ОНХО-аар 2024 онд нийт 43,355.2 сая төгрөгийн өртөгтэй 178 ТАХ-г бүрэн хэрэгжүүлж дууссан ба үүнээс 10,912.5 сая төгрөгийн өртөгтэй 53 ТАХ-г ашиглагч байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. /Дүрслэл №3/

Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй
ТАХ-ний тоо



Нийт нягтлан бодох бүртгэлд тусгаагүй аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 7,398.8 сая төгрөгийн өртөгтэй 19 ТАХ, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 3,513.7 сая төгрөгийн 34 ТАХ байна. /Хавсралт №2, №3/

Шийдвэрлэлт

ОНХО-аар хэрэгжүүлж ашиглалтад оруулсан ТАХ-г данс бүртгэлд тусгаагүй, захиалагчаас ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах үүргээ хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, ашиглалт, хамгаалалтын асуудал орхигдохоор байх тул хөрөнгийг бүртгэлд тусгуулах албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2/1²³-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт 4,711.8 сая төгрөгийн өртөгтэй 14 ТАХ-ний хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал,

Замын-Үүд суманд хяналтын камер засварлах, нэмэгдүүлэх, хяналтын нэгдсэн удирдлагын систем байгуулах 326.5 сая төгрөгийн өртөгтэй 4 ТАХ, сумын гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, засварлах ажилд 101.8 сая төгрөгийг сумын ХО-ын зардлаас шийдвэрлэж зарцуулсан байгаа боловч сумын зарим байршлын гэрэлтүүлэг ажиллахгүй, камерыг хянах, бүрэн ашиглах боломж бүрдээгүй, ашиглалт хангалтгүй байгаа нь сумын ард иргэдийн амьдрах аюулгүй орчныг бий болгож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхээр хэрэгжүүлсэн ТАХ-ний зорилт хангагдаагүй байна.

ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг бүрэн тооцоолоогүй, шаардлагатай ТАХ-ний зураг, төсвийг холбогдох стандартад нийцүүлж иж бүрэн боловсруулаагүй, мөн ашиглагч байгууллага нь хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн, зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах үүргийг биелүүлэхгүй байгаагаас шалтгаалж ТАХ-ний ашиглалт бүрэн хангагдахгүй байна.

²⁰ “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”

²¹ “Засаг дарга нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”

²² “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ”

²³ “Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах эрх, үүрэгтэй”

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- ОНХО-аар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт урьдчилсан судалгаа хийх, урсгал зардлыг тооцох, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх, иргэдийн санал авах, эрэмбэлэх, сонгох зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан ТАХ-г төлөвлөж, батлаагүйгээс хэрэгжилттэй холбоотой зөрчил давтагдсан байна.
- ОНХО-ын төлөвлөлтийг төсвийн зарчмыг баримталж, шаардлагад нийцсэн ТАХ-г төлөвлөөгүйгээс ТЕЗ-ийн төсвийн төсөл хүргүүлснээс хойш хугацаанд зураг, төсөв хийсэн 22, магадлалын дүгнэлт гаргуулсан 15, техникийн нөхцөл олгосон 12, техникийн нөхцөл олгогдоогүй 4, зураг төсөлд магадлалын дүгнэлт гаргаагүй 2 ТАХ-г хэрэгжүүлсэн байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн өмчлөлд шилжих боломжгүй 3,700.8 сая төгрөгийн 36 ТАХ-г төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
- ОНХО-аар өмнө онуудад үүссэн 79 ТАХ-ний 7,901.2 сая төгрөгийн санхүүжилтийн өглөгөөс 2024 онд 51 ТАХ-ний 5,953.8 сая төгрөгийн өрийг гүйцэтгэгч компаниудад шилжүүлж, 28 ТАХ-ний өрийг бүрэн барагдуулан, оны эцсийн байдлаар 51 ТАХ-ний 1,947.4 сая төгрөгийн санхүүжилтийн өрийн үлдэгдэлтэй байна.
- Дорноговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 16,213.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 67 ТАХ-ний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг сумдын ТТЗ, ашиглагч байгууллагад хуульд заасан хугацаанд шилжүүлээгүй байна.
- Сумдын Засаг дарга, ашиглагч байгууллагад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн ТАХ-ны худалдан авах ажиллагаа зохион байгуулах, захиалагч, зохиогчийн хяналт хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хэрэгжүүлээгүйгээс ажлын гүйцэтгэлтэй холбоотой зөрчил гарсан байна.
- Худалдан авах ажиллагааны газар нь ОНХО-аар хэрэгжүүлэх 37 ТАХ-ны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зохион байгуулснаас гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцогч 7 аж ахуйн нэгж, байгууллага тендер шалгаруулалтын үр дүнтэй холбоотой гомдол гаргаж, 3 тендер шалгаруулалтыг дахин зарласан байна.
- Техникийн тодорхойлолтод тусгасан шаардлагыг хангаагүй тоног төхөөрөмж нийлүүлсэн, зураг төсвийн дагуу бүрэн хийгдээгүй 2 ТАХ-ний санхүүжилтэд 541.0 сая төгрөгийг олгосон байна.
- ОНХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний ажил гүйцэтгэх гэрээний хугацааг ажлын тоо хэмжээ, бусад хүчин зүйлстэй уялдуулж, бүрэн хэрэгжүүлэх хугацаагаар байгуулаагүйгээс 2024 онд хэрэгжүүлж дуусгах 199 ТАХ-ний 151 ТАХ-г гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлж, 13 ажил төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна.
- Зураг, төсвийн дагуу бүрэн, чанартай хийгдээгүй 5,639.3 сая төгрөгийн өртөгтэй 9 ТАХ-г ашиглалтад хүлээн авсан нь ОНХО-ыг үр дүнгүй зарцуулах, гүйцэтгэгч компанийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт хангагдахгүй байх нөхцөл үүссэн байна.
- ОНХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байгаагаас хөрөнгө оруулалтын хэрэгжилттэй холбоотой зөрчил буурахгүй байна.
- Бүрэн хэрэгжиж дууссан 10,912.5 сая төгрөгийн өртөгтэй 53 ТАХ-г ашиглагч байгууллагын НББ-д тусгаагүй байна.

Аудитаар нийт 29,410.0 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 91.9 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах тухай 22,200.0 сая төгрөгийн 9 албан шаардлага, зөрчил давтан гаргахгүй байх тухай 7,118.1 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.7-д “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ” гэсэн заалтын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг шилжүүлж, ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ ТАНАА:

1. Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төсвийн төсөлд боловсруулахад тавигдах шаардлага, 29^{1.1}, 29^{1.2}-т заасан төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан, барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй, техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай ТАХ-д ТЭЗҮ, урьдчилсан судалгааг хийлгэсэн, урсгал зардлыг тооцсон, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан, олон нийтээр хэлэлцүүлсэн зэрэг шаардлагыг хангасан байх” гэсэн заалтын дагуу хөрөнгө оруулалтын төсөлд тусгуулах ТАХ-ний саналд шаардлагатай баримт материалыг бүрэн бүрдүүлж, хуульд заасан хугацаанд ТЕЗ-д хүргүүлж байх.
2. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 12 дугаар зүйлийн 12.1 “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана”, 12.5 “Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд “эсхүл түүнтэй дүйцэх гэсэн тодотгол хэрэглэнэ” гэсэн заалттай нийцэхүйц тендерийн баримт бичгийг боловсруулж, өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ХАА-г зохион байгуулах. /2025 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний эрхийг сумдад шилжүүлээгүй талаар аймгийн ЗДТГ-аас тайлбар ирүүлсэн тул тус зөвлөмжийг зөрчлийн дүнд оруулаагүй болно/

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

САНАЛ №1



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ

Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 3009, Факс: (976) 7052 3140,
Цахим шуудан: dornogobi.ith@gmail.com

2025.05.23 № 06/128

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд аймгийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа улс, орон нутгийн бодлого шийдвэртэй уялдсан, холбогдох хууль, журмын шаардлагад нийцсэн, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, төсөл арга хэмжээ хөрөнгө оруулалтын ажлыг дэмжин баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Ц.БАТСУГИР



448250217

САНАЛ №2



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: 7052 2533, Факс: (976) 7052 2530,
Цахим шуудан: zdtg@dornogovi.gov.mn,
Цахим хуудас: www.dornogovi.gov.mn

2025.05.23 № 01/844

танай 2025.05.21 -ны № 1-6/443 -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”
сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Аудитын тайлантай холбоотой саналгүй
болно.


О.БАТЖАРГАЛ

4425110612
D/2022/toot-A5

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж, хэрэгжүүлсэн
хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, хөрөнгөд бүртгэх боломжгүй
ТАХ-ний жагсаалт**

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Санхүүжилт
1	Замын-Үүд сумын 48 айлын орон сууц /130, 131, 134/ гадна фасадны ажил	321.9	293.9	291.4
2	Замын-Үүд сумын 64 айлын орон сууцны гадна фасад засварлах ажил	364.9	327.6	324.8
3	Замын-Үүд сумын 72 айлын орон сууцны гадна фасад засварлах ажил	233.1	223.1	221.2
4	Замын-Үүд сумын нийтийн орон сууц 136 дугаар байрны гадна фасад засварлах ажил	188.1	183.4	183.4
5	Замын-Үүд сумын нийтийн орон сууц 133 дугаар байрны гадна фасад засварлах ажил	140.1	126.4	126.4
6	Замын-Үүд сумын нийтийн орон сууц 135 а байрны гадна фасад засварлах ажил	189.3	184.6	184.6
7	Замын-Үүд сумын нийтийн орон сууц 135 б байрны гадна фасад засварлах ажил	184.9	178.8	178.8
8	Барилга байгууламжийг паспортжуулах ажил	100.0	100.0	-
9	Ноён хутагтын 123 дугаар байрны цахилгаан шатны засварт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил	20.0	20.0	20.0
10	Сайншанд сумын 1 дүгээр багийн зарим нийтийн орон сууцанд урсгал засвар хийх ажил	10.0	10.0	10.0
11	Замын-Үүд нийтийн орон сууц 117 дугаар байрны гадна фасадын засварын ажил	111.3	105.7	105.7
12	Нефть 12 айлын орон сууцны барилгын гадна фасадын засварын ажил	87.4	-	-
13	Шалганы 60 айлын байрны гадна фасад засварын ажил	165.9	-	-
14	Сүлд багийн 159 дүгээр байрны гадна фасадын засварын ажил	130.2	117.8	116.8
15	Хилчин багийн Орентал байрны гадна фасадын засварын ажил	149.4	139.8	138.6
16	Соёмбо багийн Шүүхийн ажилчдын байрны гадна фасадын засварын ажил	100.7	96.5	95.6
17	Нийтийн эзэмшлийн зам, талбайг, цэцэг, зүлэгжүүлэх ажил	20.0	19.9	19.9
18	Халиун кабелийн хуучин кабель шугамыг буулгах ажил	19.0	19.0	19.0
19	Төв саадны хашааг засварлах ажил	18.0	17.9	17.9
20	Төв саадны хөшөө, дурсгал сэргээх ажил	20.0	20.0	20.0
21	"Мандах Наран -2" хорооллын гадна зам талбайн ажил	902.1	902.1	453.3
22	Хяналтын камер засварлах ажил	12.2	12.2	12.2
23	Гэр хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайг засварлах ажил	20.0	19.5	19.5
24	Сүлд багийн 1 дүгээр ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	11.0	11.0	11.0
25	Сүлд багийн 3 дугаар ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	11.0	11.0	11.0
26	Борхойн багийн 5 дугаар ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	11.0	11.0	11.0
27	Хилчин багийн 14 дүгээр ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	11.0	11.0	11.0
28	Жаргалант багийн 12 дугаар ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	11.0	11.0	11.0
29	"Замын-Үүд Нийтийн Аж Ахуй Үйлчилгээ" ОНӨ ХХК-д сэлбэг хэрэгсэл худалдан авах	20.0	19.5	19.5
30	2-р уурын зуухыг буулгах ажил	17.0	-	-
31	Замын-Үүд сумын Шүүхийн тамгын газарт киоск машин худалдан авах ажил	8.5	8.5	8.5
32	Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт ур чадварын хэрэглэгдэхүүн худалдан авах ажил	18.8	18.8	18.8
33	Замын-Үүд сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгт сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах ажил	19.0	19.0	19.0
34	Замын-Үүд сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгт сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах ажил	19.0	19.0	19.0
35	Замын-Үүд сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгт сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах ажил	19.0	19.0	19.0
36	Соёмбо талбайн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг засварлах ажил	16.0	15.9	15.9
Нийт дүн		3,700.80	3,292.90	2,733.80

Аймгийн ОНХО-аар хэрэгжүүлсэн нягтлан бодох бүртгэлд тусгаагүй хөрөнгийн жагсаалт

/төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Гэрээний дүн
		Эхлэх	Дуусах		
1	Даланжаргалан сумын Их нартын байгалийн нөөц газрын тусгай хамгаалалттай захиргааны гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил	2024	2024	53,180,000.0	48,447,000.00
2	Замын-Үүд сумын ШШГХ-ийн өргөтгөл барих ажил	2024	2024	54,236,000.0	54,197,722.00
3	Иххэт сумын Цагдаагийн кабоны барилгын их засварын ажил	2024	2024	154,247,000.0	148,202,094.00
4	Улаанбадрах суманд Дулааны уурын зуух болон тоног төхөөрөмж худалдан авах ажил /2ш/	2024	2025	600,000,000.0	565,388,040.00
5	Аймгийн Төв номын сангийн барилгын дотор халаалтын системийн засварын ажил	2024	2024	142,159,000.0	122,601,673.00
6	Асрамжийн газрын үерийн усны далан хийх ажил	2024	2024	107,800,000.0	101,172,611.00
7	Замын-Үүд чиглэлд төмөр замын гармаас Шунхлай ШТС хүртэл 2.8км гэрэлтүүлэг шинээр хийх	2024	2025	671,614,200.0	660,200,316.00
8	Сайншанд сумын 4,7-р баг, арын 3-н замын уулзвараас төмөр замын гарам хүртэл 2.1 км автозамд гэрэлтүүлэг хийх ажил	2024	2024	385,100,000.0	318,547,887.00
9	Сайншанд сумын 1, 6, 7 дугаар баг "Тэс петролиум" ХХК-ийн ШТС-ын тойргоос офицерын төв зам хүртэлх 3.6 км авто замын гэрэлтүүлэг хийх ажил	2024	2025	650,000,000.0	595,098,899.00
10	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт компьютер томографын аппарат худалдан авах ажил	2024	2024	350,000,000.0	350,000,000.00
11	Сайншанд сумын 7 дугаар баг "Тэс петролиум" ШТС-ын 3-н замын уулзварын тойргийн өргөтгөл автозам барих ажил	2024	2025	176,000,000.0	175,959,036.00
12	Сайншанд сумын 7-р баг "Гор газ" ШТС-ын уулзвараас баруун тийш үргэлжлэх автозамаас Мандах наран-5 хороолол хүртэлх 0.16 км автозам барих ажил	2024	2025	314,216,000.00	313,356,946.00
13	Сайншанд 7-р баг "Гор газ" ШТС-ын уулзвараас баруун тийш үргэлжлэх 1.59 км автозам гэрэлтүүлэг хийх ажил	2024	2024	237,240,000.00	235,082,909.00
14	Айраг сумын ЕБС-ийн 1-р байрны их засварын ажил	2023	2024	822,979,600.0	790,483,670.00
15	Алтанширээ сумын төвийн нийтийн орон сууцыг гадна дулаан цэвэр усны шугамд холбох ажил	2023	2024	415,867,000.0	401,190,829.00
16	Иххэт сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн угсралтын ажил	2023	2024	369,293,000.0	344,877,081.00
17	Сайншанд сумын 7-р баг Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн бага сургуулийн урд авто замыг үргэлжлүүлэн Зүүн буянт ухаа, Дунд буянт ухаа гудамжны дундуур урагшаа чиглэлд төв авто замтай холбох авто зам шинээр барих /700м/	2023	2024	844,478,000.0	795,826,574.00
18	Сайншанд сумын 6-р баг, Шинэ зууны гудамжны автозамд нөхөөс хийх, явган хүний зам, дугуйн зам шинээр барих ажил /2.2 км/	2023	2024	910,650,000.0	910,645,214.00
19	Замын-Үүд сумын 1-р багийн Уужим дэлгүүрийн уулзвараас Заан зоог хүртэлх 274м асфальт зам /явган зам гэрэлтүүлэг/	2023	2024	467,604,000.00	467,550,639.00
Нийт				7,726,663,800.0	7,398,829,140.0

Замын-Үүд сумын ОНХО-аар хэрэгжүүлсэн нягтлан бодох бүртгэлд тусгаагүй хөрөнгийн жагсаалт

/төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Гэрээний дүн
		Эхлэх	Дуусах		
1	Мандах наран-2 хорооллын дэд бүтцийн ажил	2023	2024	226,649,836	226,649,836
2	Орентал байрнаас Элгэн баян дэлгүүр хүртэлх хавтан зам тавих ажил	2023	2024	234,035,629	234,035,629
3	Сумын нутаг дэвсгэрт шинээр гэрэлтүүлэг хийх ажил	2023	2024	320,000,000	269,186,198
4	Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч Гадаадын иргэн харьяатын газарт ажилчдын орон сууц худалдан авах ажил	2024	2024	392,500,000	391,000,000
5	Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч Гадаадын иргэн харьяатын газарт тавилга, эд хогшил худалдан авах ажил	2024	2024	800,000,000	625,170,000
6	Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч Гадаадын иргэн харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын барилгын урсгал засварын ажил	2024	2024	200,000,000	196,431,624
7	Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч Гадаадын иргэн харьяатын газрын төв байрны урсгал засварын ажил	2024	2024	357,500,000	353,489,397
8	Сүлд багийн 1 дүгээр ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	2024	2024	11,000,000	11,000,000
9	Сүлд багийн 3 дугаар ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	2024	2024	11,000,000	11,000,000
10	Борхойн багийн 5 дугаар ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	2024	2024	11,000,000	11,000,000
11	Хилчин багийн 14 дүгээр ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	2024	2024	11,000,000	11,000,000
12	Жаргалант багийн 12 дугаар ус түгээх байранд автоматжуулалт хийх ажил	2024	2024	11,000,000	11,000,000
13	Замын-Үүд сумын цаг уурын станцын барилгын цэвэр, бохир усны шугамын засварын ажил	2024	2024	16,702,142	16,702,142
14	Хог тээврийн автомашин худалдан авах ажил /Кама/	2024	2024	8,200,000	8,200,000
15	Хог тээврийн шахагч автомашин худалдан авах ажил	2024	2024	25,000,000	111,458,000
16	"Замын-Үүд Нийтийн Аж Ахуй Үйлчилгээ" ОНӨХХК-д сэлбэг хэрэгсэл худалдан авах	2024	2024	19,500,000	19,500,000
17	Нийтийн эзэмшлийн зам, талбайг, цэцэг, зүлэгжүүлэх ажил	2024	2024	20,000,000	19,900,000
18	Онцгой байдлыг хэлтэс шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	2024	2024	19,600,000	19,600,000
19	Халиун кабелийн хуучин кабель шугамыг буулгах ажил	2024	2024	19,000,000	18,990,000
20	Соёмбо талбайн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг засварлах ажил	2024	2024	16,000,000	15,900,000
21	Төв садны хашааг засварлах ажил	2024	2024	18,000,000	17,900,000
22	Сумын хэмжээнд гэрэлтүүлэг засварлах ажил	2024	2024	20,000,000	19,900,000
23	Төв садны хөшөө, дурсгал сэргээх ажил	2024	2024	20,000,000	20,000,000
24	"Борхойн Наран" өрхийн эрүүл мэндийн төвийн гадна талбайд авто зогсоол хийх ажил	2024	2024	17,000,000	17,000,000
25	Дулаан дамжуулах төв 11-ээс Элгэн баян дэлгүүр чиглэлийн 380м урт дулааны шугам шинээр угсрах ажил	2024	2024	114,012,368	103,500,123
26	Хилийн шалган нэвтрүүлэх 3 дугаар хаалт дээр 203м хавтан зам тавих ажил	2024	2024	20,000,000	20,000,000
27	Хилийн шалган нэвтрүүлэх 3 дугаар хаалтын уулзвараас Хараа дэлгүүрийн уулзвар хүртэлх 2.1 км авто замын гэрэлтүүлгийн ажил	2024	2024	394,470,481	356,909,414
28	Геодезийн цэг, тэмдэгт шинээр хийх ажил	2024	2024	20,000,000	9,990,000
29	Сумын төвийн хэсгийн гэрэлтүүлгийн шонгийн туузан гэрэл шинэчлэн засварлах ажил	2024	2024	18,768,000	18,768,000
30	Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт ур чадварын хэрэглэгдэхүүн худалдан авах ажил	2024	2024	18,806,700	18,806,700
31	Замын-Үүд сумын сум дундын цагдаагийн хэлтэст камерын хяналтын дэлгэц худалдан авах ажил	2024	2024	19,947,900	19,947,900
32	Хяналтын камер засварлах ажил	2024	2024	12,182,870	12,182,870
33	"Замын-Үүд Дулааны Станц" ТӨҮГ-т өөрөө буулгагч авто машин худалдан авах ажил	2024	2024	220,000,000	215,600,000
34	Хилийн шалган нэвтрүүлэх 3 дугаар хаалтын уулзвараас Хараа дэлгүүрийн уулзвар хүртэлх 2.1 км авто замын гэрэлтүүлгийн ажлын нэмэлт	2024	2024	12,000,000	12,000,000
Нийт				3,821,675,926	3,513,717,833